

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шинэ дөрвөлжин” ХХК ОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код:ЗАА-2022/04/СТА-ОНӨААН

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. Санхүүгийн тайлангийн аудитын тодруулга	
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Дотоод хяналт	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
4.4 Материаллаг байдал	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. Засврын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

 ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 81090 Улаанбаатар, Завхан аймаг Утас/Факс: 7046-36-12 И-мэйл: zavkhan@audit.gov.mn	“ШИНЭ ДӨРВӨЛЖИН” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.БАТТУЛГА-Д
2022.03.15 № 1302-435 танай _____ -ны № _____ -т Татгалзсан дүгнэлт	
Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. “Шинэ дөрвөлжин” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна. Дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. <i>Санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд гаргаж өгөөгүй; Өмнөх оны авлага 1,0 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн; Тайлант онд батлагдсан төсөв төлөвлөгөө байхгүй; Стандарт маягтаар санхүүгийн тайлангаа гаргаж хэвшээгүй; Компанийн үйл ажиллагаа тогтмол биш, тогтсон мэргэжлийн нягтлан бодогч ажиллаагүй; Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй;</i> Эдгээр зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дугаар зүйлийн 9, 20 дугаар зүйлийн 3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4,2; 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6; Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 заалтууд, Сангийн сайдын 386 тоот тушаалын 3-р хавсралтыг зэргийг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна. 013025479	

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	62,513.40	107,164.38
1.1.2	Дансны авлага	1,000,000.00	
1.1.6	Барaa материал	75,000.00	75,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,137,513.40	182,164.38
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	582,879.45	519,879.45
1.2.7	Эргэлтийн бус хөрөнгө	51,004,000.00	51,004,000.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	51,586,879.45	51,523,879.45
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	52,724,392.85	51,706,043.83
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1.	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,622,169.70	5,768,698.12
2.1.1.3	Татварын өр	756,277.93	801,640.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг		880,000.49
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,378,447.63	7,450,338.61
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,378,447.63	7,450,338.61
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	89,400.00	89,400.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	51,004,000.00	51,004,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(747,454.78)	(6,837,694.78)
2.3.11	Эздийн өмчийн дүн	50,345,945.22	44,255,705.22
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	52,724,392.85	51,706,043.83

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	32,000,000.00	
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	32,000,000.00	-
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	35,698,858.55	6,090,240.00
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(3,698,858.55)	(6,090,240.00)
19	Орлогын татварын зардал	-	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(3,698,858.55)	(6,090,240.00)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(3,698,858.55)	(6,090,240.00)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	89,400.00	51,004,000.00	(747,454.78)	50,345,945.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	89,400.00	51,004,000.00	(747,454.78)	50,345,945.22
4	Тайлант үеийн швэр ашиг (алдагдал)	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2020 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	89,400.00	51,004,000.00	(747,454.78)	50,345,945.22
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	89,400.00	51,004,000.00	(747,454.78)	50,345,945.22
12	Тайлант үеийн швэр ашиг (алдагдал)	-	-	(6,090,240.00)	(6,090,240.00)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2021 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	89,400.00	51,004,000.00	(6,837,694.78)	44,255,705.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,000,000.00	-
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	34,000,000.00	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	-	-
1.1.6.	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	33,960,121.60	955,349.02
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,071,366.00	568,250.00
1.2.2	Нийгэмийн даатгалын байгууллагад төлсөн	500,000.00	259,999.02
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,539,000.00	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,032,555.60	-
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	23,817,200.00	127,100.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	39,878.40	-955,349.02
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	1,000,000.00
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		1,000,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	1,000,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гартаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	39,878.40	44,650.98
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	39,878.40	44,650.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,635.00	62,513.40
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,513.40	107,164.38

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		22,635.00	-	62,513.40
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,000,000.00	33,960,121.60	-	955,349.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,000,000.00	33,960,121.60	-	955,349.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,000,000.00	33,960,121.60	-	955,349.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,000,000.00	2,071,366.00	-	568,250.00
210101	Үндсэн цалин	6,000,000.00	2,071,366.00		568,250.00
210102	Нэмэгдэл				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	960,000.00	500,000.00	-	259,999.02
210205	Эрүүл мэндийн даатгал	960,000.00	500,000.00		259,999.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	-
210301	Гэрэл цахилгаан				
210302	Түлш, халаалт				
2104	Хангамж, бараа материалын зардал	5,040,000.00	31,388,755.60	-	127,100.00
210401	Бичиг хэрэг				
210402	Тээвэр шатахуун	5,040,000.00	4,539,000.00		
210403	Шүүдэн, холбоо интернэтийн төлбөр				
210405	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил				
210406	Татварын байгууллагад төлсөн		3,032,555.60		
210407	Бусад зардал		23,817,200.00		127,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,000,000.00	34,000,000.00	-	1,000,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,000,000.00	34,000,000.00	-	1,000,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	12,000,000.00	11,000,000.00		
131002	Өөрийн орлого				
131003	Авлагаа барагдуулах		23,000,000.00		1,000,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		62,513.40		107,164.38

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

"Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН-ын үндсэн үйл ажиллагааны чиглэл нь худаг ажиллуулах, ус түгээх, айл өрхүүдийн хогийг ачуулах, төрийн байгууллагын халаалтын үйл ажиллагааг зохицуулах гэж тусгагдсан байна.

Тухайн байгууллага нь гэрчилгээнд тусгагдсан үндсэн үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаагаа явуулаагүй, улмаар үйл ажиллагаагаа явуулах талаар анхаарч ажиллаагүй, төсөв төлөвлөгөөгөө ч батлуулаагүй байна.

Цаашид тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд орон нутгаас орлого нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах, эсвэл татан буулгах шаардлагатай байна гэж үзлээ.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

"Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН нь Завхан аймгийн Дөрвөлжин суманд үйл ажиллагаагаа явуулахаар гэрчилгээн дээрээ тусгасан боловч тогтвортой үйл ажиллагаа огт явуулаагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

"Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллаагүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	62.5	107.2	44.7
Дансны авлага	1,000.0	-	-1,000.0
Бараа материал	75.0	75.0	-
Үндсэн хөрөнгө	582.8	519.8	-63.0
Эргэлтийн бус хөрөнгө	51,004.0	51,004.0	-
Нийт хөрөнгө	52,724.3	51,706.0	-1,018.3
Дансны өглөг	1,622.1	5,768.7	4,146.6
Татварын өр	756.2	801.6	45.4
НДШ - ийн өглөг	-	880.0	880.0
Өмч: - төрийн	89.4	89.4	-
Эзэмшигчдийн өмчийн бусад	51,004.0	51,004.0	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	-747.4	-6,837.7	-6,090.3
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн дүн	52,724.3	51,706.0	-1,018.3

Дээрх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг Сангийн яамны сайт дахь Санхүүгийн тайлангаас үндэслэн хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох тогтсон нягтлан бодогчгүй хариуцах эзэн холбогдогчгүй захирал Д.Баттулга нь холбоо барих боломжгүй байсан зэрэг нь ажилд тун хүндэр учруулж байсан.

Мөн сумын санхүү хариуцсан ажилтан гэх нягтлан бодогчоос бэлтгэн гаргаж сангийн яамны сайтад оруулсан мэдээллийг хэрхэн бэлтгэн боловсруулж тухайн мэдээллийг илгээсэн талаар удаа дараа холбоо барьж санхүүгийн тайлан гэх тоон мэдээллийг файлаар авахад алдаатай, санхүүгийн тайлангууд хоорондоо таарахгүй, ерөнхий журнал гүйлгээ баланс хийхгүйгнээр тайлан гаргасан би нягтлан бодогч бишээ гэсэн байдлаар хандаж байсан нь ажилд нэлээдгүй саад учруулж байсан.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллагын удирдлагууд тайлант хугацаанд төсөв, төлөвлөгөө баталж үйл ажиллагаагаа сайжруулах, тогтворжуулах талаар анхаарч ажилладаггүй улмаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу "Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад "Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН-тэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

"Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН-д 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт Төсвийн тухай хуулийн 8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй улмаар тус байгууллагад дотоод хяналт огт байхгүй.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

"Шинэ дөрвөлжин" ХХК ОНӨААН нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан гэх нягтлан бодогч нь авлага дансанд үлдэгдэлээр тусгагдсан байсан 1,000.0 мянган төгрөгийг орж ирсэн орлогоор бүртгэн дэлгэрэнгүй орлогын тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд тусгасан байгаа байгаа байдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5,"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заасан заалтыг зөрчсөн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 60.9 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зарлагын 6,090.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 60.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 42.6 мянган төгрөгөөр тогтоосон.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс нэг ч мэдээллийг оруулаагүй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит оруулах талаар удаа дараа холбоо барьсан боловч удирдлагууд утсаа аваагүй болно.

Өмнөх онд албан шаардлага 1, зөвлөмж 5 хүргүүлж улмаар хязгаарлалттай дүгнэлт хүргүүлсэн байна. Тус байгууллагын удирдлагууд нэг ч зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ибаримтын бүрдүүлэлтэнд анхаарч ажиллах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

8.1 Залруулсан алдаа:

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,000 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

- ✓ Илрүүлэлт: Өмнөх оны авлага 1,000.0 мянган төгрөгийг орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" мөн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.
- ✓ Өгсөн зөвлөмж: Орлогын тайланг зөв болгох, Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн ашиг, алдагдалыг зөв болгох, Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын хэсэгт тусгах

8.2 Төлбөрийн акт өгөгдөөгүй.

8.3 Албан шаардлага өгөгдөөгүй.

8.4 Зөвлөмж :

- ✓ Илрүүлэлт: Тайлант онд батлагдсан төсөв төлөвлөгөөгүй байх, үйл ажиллагаагаа тогтмол явуулдаггүй, тогтсон нягтлан бодогч байхгүй, хуулийн хугацаанд хүссэн мэдээллээр аудитын байгууллагыг хангадаггүй, Шилэн данс хөтөлдөггүй
- ✓ Өмнөх аудитын өгсөн 4 зөвлөмжийн 1 ширхэгийг ч хэрэгжүүлж ажиллаагүй. нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй
- ✓ Өгсөн албан зөвлөмж: Дээрх зөрчлүүд нь Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага,

төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”, 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах”; Төсвийн тухай хуулийн 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөнө”, 8.2-т “Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.”, 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”; Төсвийн тухай хуулийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх,” /тогтоосон шийдвэр/

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1						1
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1						1

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	2	1.0	1	1.0					1	
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	0									0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН	2	1.0	1	1.0					1	

